

НЭГ. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

1. Үндэсний үнэт зүйл, эх хэл, уламжлалт өв соёлоо дээдэлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэдийг соён гэгээрүүлнэ.
2. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.
3. Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

1. Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, дундаж наслалтыг уртасгана.
3. Гэр бүл болон хүн амын бүлгүүдэд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжил, оролцоо, хамгааллын үр ашигтай орон нутгийн тогтолцоог бэхжүүлнэ.
4. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, гарааны компанийг дэмжих, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг Төр- хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлж инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээ, өндөр технологийн үйлдвэрлэлийн тоог нэмэгдүүлнэ.
5. Хүнд ээлтэй эрүүл баталгаат амьдрах орчин бий болгоно.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

1. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, даатгалын ээлтэй орчныг бүрдүүлнэ.
2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.
3. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулан ажилгүйдлийн түвшинг 3.6 хувьд хүргэнэ.
4. Хүн амыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх таатай орчин бүрдүүлж, их спортыг хөгжүүлж, шилдэг тамирчдыг бэлтгэнэ.
5. Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

1. Эдийн засгийн бүтэц дэх боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарыг дэвшилтэт технологи, инновацид суурилан хөгжүүлж, ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг 12 хүртэл хувиар өсгөн, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.

2. Аймгийн орон зай, бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн түүхий эдийн нөөц, байгалийн баялаг, нутаг дэвсгэрт байгуулагдах хотуудын хөгжлийн төлөвт тулгуурлан боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлж “Хөдөө аж ахуйн стратегийн бүс нутаг”, “Бэлтгэн нийлүүлэгчээс үйлдвэрлэгч аймаг”, “Хүнс үйлдвэрлэгч, экспортлогч улс болох Засгийн газрын зорилтыг хангах түшиц аймаг” болж Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувийн жинг 20 хувьд хүргэнэ.

3. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.

4. Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засагжуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

ТАВ. ЗАСАГЛАЛ

1. Нутгийн удирдлагын бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэн, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг бүрдүүлнэ.

2. Төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар дээд байгууллагаас гарсан шийдвэрийг чанд мөрдөн иргэдийн оролцоог зохист түвшинд ханган хувийн хэвшилтэй хамтарч ажиллах бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, үр дүнтэй цахим засаглал, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих бодлогыг хэрэгжүүлнэ.

4. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм, хэмжээ стандартыг нэвтрүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

5. Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох ажлыг үе шаттай зохион байгуулж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтлан хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, хандлагыг өөрчилнө.

6. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлж, ил тод, нээлттэй хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.

ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ

1. Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээн, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.
2. Усны нөөцийг хамгаалах, хуримтлал бий болгох, хомсдол бохирдлоос сэргийлэх, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.
3. Байгальд хал багатай, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.

ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.
2. Иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх замаар нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.
3. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах хөтөлбөрийн хүрээнд гамшгаас урьдчилсан сэргийлэх сургалт сурталчилгаанд жилдээ 10000 доошгүй иргэдийг хамруулж, иргэдийн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоонд тулгуурлан бууруулна.
4. Хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлнэ.
5. Иргэд, байгууллагад үзүүлэх эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
6. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, халдлагад хариу үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ.

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

1. Сумын төв, суурин газруудыг ногоон хөгжлийн стандарт, загварт нийцүүлэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
2. Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүс бүхий эко хотыг хөгжүүлнэ.
3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартын хангалтыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлж, цөм сүргийн малын сүрэгт эзлэх хувийн жинг 13-аас доошгүй хувьд хүргэнэ.

5. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн тариалангийн талбайн ашиглалтыг 80-аас доошгүй хувьд хүргэж, салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

ЗДТГ-ын дарга В.Болортуяа

Холбоо барих утас: 88095853

Цахим шуудан: Jargalant1927@gmail.com